



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/539

Улаанбаатар хот

“Оюутны клубийн үйл ажиллагааны журам”  
батлах тухай


Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь хэсэг, МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.5, дахь хэсэг, МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны журмын 3.2.3.2 дахь хэсэг, Оюутны хөгжлийн хөтөлбөрийн 2.1 дэх хэсэг, Ректорын зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-ийн “Оюутны клубийн үйл ажиллагааны журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, Клубэд бүртгүүлэх өргөдлийн загварыг 2 дугаар хавсралтаар, Хурлын тэмдэглэл, гишүүдийн бүртгэлийн загварыг 3 дугаар хавсралтаар, Жилийн ажлын төлөвлөгөөний маягыг 4 дүгээр хавсралтаар, Төсөвт үйл ажиллагааны удирдамжийн загварыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Оюутны клубийн үйл ажиллагааны журам”-ыг 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлэхийг Оюутны хөгжлийн газрын дарга (Б.Цэцэнцолмон), Сургалт, хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын газрын дарга (С.Булгантамир), Цахим шилжилтийн газрын дарга (А.Баатарбилэг), Санхүү, бүртгэлийн газрын дарга (Н.Халиун), бүрэлдэхүүн/салбар сургуулийн захирал (Б.Амарсанаа, Н.Батнасан, Б.Болд-Эрдэнэ, Б.Ганбат, О.Мөнхбат, С.Мөнхбат, Ч.Сономдагва, Д.Алтанхуяг, Ц.Пүрэвсүрэн, Б.Мядагмаа), тэнхимийн эрхлэгч нарт тус тус даалгасугай.

3. “Оюутны клубийн үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Д.Заяабаатар)-т үүрэг болгосугай.

РЕКТОР



Б.ОЧИРХУЯГ

1425064738

Монгол улсын их сургуулийн ректорын  
2025 оны 11 сарын 17-ний/ны өдрийн  
А/539 тоот тушаалын 01 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ОЮУТНЫ КЛУБИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

ATA13089 9104399  
9024080427


Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журам нь Монгол Улсын Их Сургууль (цаашид "МУИС" гэх)-ийн дүрэм, холбогдох журмын хүрээнд оюутны клубийн үйл ажиллагааг дэмжихэд оршино.
2. Клубийн үйл ажиллагаа нь ил тод, хүртээмжтэй, улс төр, шашны байгууллагаас хараат бус байх бөгөөд оюутны хөгжлийг дэмжихэд чиглэнэ.

Хоёр. Журмын нэр томьёо

1. Оюутны хөгжил, үйлчилгээ хариуцсан нэгж гэж оюутны хөгжил, үйлчилгээний нэгжийн удирдлага, хариуцсан мэргэжилтнийг;
2. Холбогдох нэгж гэж бүрэлдэхүүн/салбар сургууль, тэнхим, захиргааны нэгж, төвийг;
3. Зөвлөх багш гэж клубийн үйл ажиллагаанд мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх багшийг;
4. Клуб гэж суралцаж буй мэргэжлийн чиглэл болон сайн дурын үндсэн дээр нэгдэж, оюутны хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулдаг бүлгийг;
5. Клубийн тэргүүн гэж нийт гишүүдийн саналаар сонгогдсон, клубийг төлөөлөх, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх эрх бүхий оюутныг;
6. Клубийн нарийн бичгийн дарга гэж клубийн үйл ажиллагааны зохион байгуулалт, бичиг хэрэг хариуцдаг оюутныг;
7. Клубийн гишүүн гэж мэргэжлийн болон сайн дурын клубийн гишүүнчлэлийн шаардлагыг хангаж гишүүнээр элссэн оюутныг;
8. Клубийн батламж гэж нэг хичээлийн жилээс дээш хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулсныг баталгаажуулсан баримтыг;
9. Клубийн үйл ажиллагааны төлөвлөгөө гэж тухайн хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго, хугацаа, хариуцагч, нөөц зэргийг тусгасан төлөвлөгөөг;
10. Төсөвт үйл ажиллагаа гэж МУИС-ийн стратеги, хичээлийн жилийн төлөвлөгөө, оюутны хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдсан МУИС-ийн хэмжээнд болон нийгэмд чиглэсэн тодорхой төсөв бүхий хөтөлбөрт үйл ажиллагааг;
11. Төсөвт үйл ажиллагааны тайлан гэж оюутны хөгжлийг дэмжих төсвөөс санхүүжилт авч хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээний санхүүгийн баримт, зарцуулалтыг тусгасан баримт бичгийг;

12. Клубийн үйл ажиллагааны тайлан гэж төлөвлөгөөт ажлын явц, хүрсэн үр дүн, үнэлгээ, ажлын гүйцэтгэлээ сайжруулах санал бүхий баримт бичгийг;
13. Анги, танхимын хуваарь гэж клубийн хурал, уулзалт, хөтөлбөрт үйл ажиллагаа зохион байгуулах сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректорын баталсан зөвшөөрлийг;



Гурав. Клубийн зорилго, зорилт, үйл ажиллагаа, чиглэл

1. Клубийн зорилго нь МУИС-ийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөө, Оюутны хөгжлийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилго, зорилтыг үндэслэн оюутны суралцах үйл явц, хувь хүний хөгжил, нийгмийн оролцоог дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд чиглэсэн, тогтвортой, хүртээмжтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино.
2. Клубийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, дараах чиглэлтэй байна. Үүнд:
  1. Оюутны мэдлэг ур чадвар, суралцах, судалгаа хийх арга барилыг дээшлүүлэх, инновац, гарааны компани байгуулахыг дэмжих, авьяас, ур чадварыг хөгжүүлэх;
  2. Монгол үндэсний соёл, өв уламжлалыг түгээн дэлгэрүүлэх;
  3. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжих;
  4. Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулах;
  5. Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх;
  6. Манлайлал, удирдан зохион байгуулах, бизнесийн ур чадварыг хөгжүүлэх;
  7. Гадаад хэл, соёлын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх;
  8. Харилцааны болон илтгэх ур чадварыг хөгжүүлэх;
  9. Шинжлэх ухаан, танин мэдэхүйн сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах;
  10. Соёл урлаг, спортын авьяас ур чадварыг хөгжүүлэх;
  11. Гадаад оюутны нийгмийн оролцоог нэмэгдүүлэх;
  12. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг тэгш хамруулах, тэгш оролцоог хангах;


Дөрөв. Клубийг бүртгэх, хасах

1. Клубийг бүртгүүлэхдээ 15-аас доошгүй оюутан нэгдэж, клуб байгуулах хүсэлтийг гаргах бөгөөд дараах материалыг бүрдүүлэн Оюутны хөгжил, үйлчилгээ хариуцсан нэгжид ирүүлнэ:
  1. Клуб бүртгүүлэх өргөдөл (хавсралт 2);
  2. Хурлын тэмдэглэл, гишүүдийн бүртгэл (хавсралт 3);
  3. Жилийн ажлын төлөвлөгөө (хавсралт 4);
2. Клубийг дараах үндэслэлээр бүртгэлээс хасна:
  1. МУИС-ийн дүрэм, холбогдох журмыг зөрчсөн;
  2. Клубийн зорилго хэрэгжиж дууссан буюу нийт гишүүдийн хүсэлтээр;
  3. Хоёр болон түүнээс дээш жилийн хугацаанд идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй;

4. Улс төр, шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулсан;
5. Төсөвт үйл ажиллагааны санхүүгийн тайлан тооцоог ирүүлээгүй;

Тав. Бүтэц, зохион байгуулалт, гишүүнчлэл

1. Клубийн бүтэц, зохион байгуулалтыг бүх гишүүдийн хурлаар батална.
2. Клубийн бүтэц нь тэргүүн, нарийн бичгийн дарга, гишүүд (шаардлагатай бол хяналтын зөвлөл)-тэй байж болно.
3. Гишүүнчлэл нь МУИС-ийн оюутанд нээлттэй байна.
4. Клуб нь зөвлөх багштай байж болно.




Зургаа. Талуудын эрх, үүрэг:

1. Оюутны хөгжил, үйлчилгээ хариуцсан нэгж дараах эрх, үүрэгтэй:
  1. Клубийн үйл ажиллагаа, төлөвлөгөө, тайлан, төсөвт хяналт тавих;
  2. Клуб, зөвлөх багшийг бүртгэх, хасах;
  3. Клубийн үйл ажиллагаа явуулах анги, танхимыг хүсэлтийн дагуу олгох;
  4. Оюутны хөгжлийн хөтөлбөрийн дагуу оюутны идэвх, оролцоог бүртгэж, цагийн үнэлгээг тооцох;
  5. Клубийн үйл ажиллагааг бодлого, стратегийн зорилттой уялдуулан дэмжих;
  6. Клубийн өдөрлөг, чадавхжуулах сургалт үйл ажиллагааг зохион байгуулах;
2. Клуб дараах эрх, үүрэгтэй:
  1. МУИС-ийн дүрэм, холбогдох журмыг мөрдөх;
  2. МУИС-ийн оюутны цахим хуудас, албан ёсны сувгаар мэдээ, мэдээллээ сурталчлуулах,
  3. МУИС-ийн дүрэм журмын хүрээнд гадаад, дотоод байгууллагатай хамтран ажиллах;
  4. МУИС-ийн лого, барааны тэмдэгтийг ашиглахдаа "МУИС-ийн барааны тэмдэг ашиглах тухай журам"-ын 7 дахь заалтыг баримтлах;
  5. МУИС-аас зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;
  6. МУИС-ийн анги танхим, лаборатори, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг эвдрэл, гэмтэлгүй ашиглах, учирсан хохирлыг барагдуулах;
  7. Жилийн төлөвлөгөө, тайлан, төсөвт үйл ажиллагааны тайланг хугацаанд нь ирүүлэх;
3. Клубийн тэргүүн, нарийн бичгийн дарга, гишүүд дараах эрх, үүрэгтэй:
  1. Клубийн тэргүүн, нарийн бичиг нь гишүүдийн бүртгэлийг бүртгэж, шинэчилж байх;
  2. Клубийг төлөөлөх, удирдан чиглүүлэх, оюутны хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг санаачлах, зохион байгуулах;
  3. Клубийн тэргүүн нь гишүүдийн идэвх санаачилгыг үнэлж, клубийн гишүүдэд тодорхойлолт гаргаж өгөх;
  4. МУИС, Оюутны хөгжил, үйлчилгээ хариуцсан нэгжээс зохион байгуулж буй чадавхжуулах сургалт, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;
  5. Оюутны хөгжлийн хөтөлбөрийн журмын хавсралтад заасны дагуу цагийн гүйцэтгэлээ тооцуулах;

4. Зөвлөх багш дараах эрх, үүрэгтэй:

1. Клубийн үйл ажиллагааг чиглүүлж, зөвлөх багшаар ажилласныг 1 ББ В цагаар тооцуулж, хичээлийн жилийн эцэст захирлын тушаалаар баталгаажуулах;
2. Клубийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх, чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх;
3. Клубийн төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагааны тайлантай танилцах, санал, дүгнэлт өгөх;



Долоо. Санхүүжилт, тайлан, урамшуулал

1. Клубийн санхүүжилт нь МУИС-ийн оюутны хөгжлийг дэмжих төсөв, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын дэмжлэг, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээс бүрдэнэ.
  1. Төсөвт үйл ажиллагааны удирдамж (Хавсралт 5)-ийг үйл ажиллагаа зохион байгуулахаас 7-14 хоногийн өмнө Оюутны хөгжил, үйлчилгээ хариуцсан нэгжид ирүүлнэ.
  2. Төсөвт үйл ажиллагааны тайланг санхүүгийн баримтын хамт ажлын 5 хоногийн дотор санхүү хариуцсан нэгжид хүргүүлнэ.
  3. Ивээн тэтгэгчийн нэр, логог ашиглах бол үйл ажиллагааны удирдамжид тусгасан байна.
2. Клуб нь хичээлийн жилийн турш тогтвортой үйл ажиллагаа явуулж, шаардлага хангасан тайлан ирүүлсэн тохиолдолд батламж олгоно. Олгосон батламжийг хоёр жил тутам сунгана.
3. Клубийн жилийн үйл ажиллагааны тайланд үндэслэн Оюутны хөгжил, үйлчилгээ хариуцсан нэгж МУИС-ийн "Шилдэг клуб"-ийг шалгаруулж, урамшуулал олгож болно.

Найм. Бусад

1. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг клуб, холбогдох нэгж гаргаж болно. Өөрчлөлтийн саналыг Оюутны хөгжил, үйлчилгээ хариуцсан нэгж боловсруулж батлуулна.

---oOo---

Монгол улсын их сургуулийн ректорын  
2025 оны 11 сарын 17-ний/ны өдрийн  
А/1539 тоот тушаалын 2 дугаар хавсралт



## КЛУБ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Клуб бүртгүүлэх хүсэлт:

Клубийн нэр: \_\_\_\_\_

Клубийн чиглэл: \_\_\_\_\_

Үүсгэн байгуулагч гишүүдийн тоо: \_\_\_\_\_

Холбоо барих мэдээлэл (тэргүүний нэр, утас, и-мэйл): \_\_\_\_\_

Клуб байгуулах зорилго, товч тайлбар:

.....  
.....  
.....  
.....  
.....

Хүсэлт гаргасан:

Овог, нэр: .....


Бүрэлдэхүүн/ салбар сургуулийн мэдээлэл: .....

SISI ID: .....

Холбоо барих утас: .....

20.... оны .... сарын ..... өдөр

Монгол улсын их сургуулийн ректорын  
2025 оны 11 сарын 11-ний өдрийн  
А/539 тоот тушаалын 03 дугаар хавсралт



### ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ, ГИШҮҮДИЙН БҮРТГЭЛ

20.... оны .... сарын ..... өдөр Улаанбаатар хот, МУИС-ийн ..... -р байр..... тоот

Хэлэлцсэн нь:

МУИС-ийн оюутны клубийн үйл ажиллагааны журмын 1.1, 1.2, 4.1 дэх заалтыг үндэслэн дараах нэр бүхий оюутнууд хуралдаж, ..... клубийг үүсгэн байгуулах талаар хэлэлцэв.

Асуулт:

Хариулт:

Шийдвэрлэсэн нь:

Хуралдаанаар ..... клубийг үүсгэн байгуулах талаар хэлэлцэн, хуралд оролцсон нийт оюутнуудын ..... хувийн саналаар ..... клубийг үүсгэн байгуулж, ..... овогтой ..... -ийг тэргүүнээр, ..... овогтой ..... -ийг нарийн бичгийн даргаар сонгон холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн оюутны хөгжил, үйлчилгээ хариуцсан нэгжид хүргүүлэн клубийг албан ёсоор бүртгүүлэх ажлыг зохион байгуулахаар шийдвэрлэв.


Хуралд оролцсон оюутнууд бүртгэлийн маягтад мэдээллээ бөглөж гарын үсэг зурна.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: .....

Хуралд оролцсон оюутнуудын бүртгэл:

| № | Овог, нэр | Бүрэлдэхүүн/<br>салбар сургууль,<br>хөтөлбөр | Оюутны ID | Утас | Гарын<br>үсэг |
|---|-----------|----------------------------------------------|-----------|------|---------------|
|   |           |                                              |           |      |               |
|   |           |                                              |           |      |               |
|   |           |                                              |           |      |               |
|   |           |                                              |           |      |               |
|   |           |                                              |           |      |               |


Монгол улсын их сургуулийн ректорын  
 2025... оны 11. сарын 18-ний/ны өдрийн  
 А/539 тоот тушаалын 04 дүгээр хавсралт



ЖИЛИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ МАЯГТ

| № | Үйл ажиллагаа<br>ны нэр | Хэрэгжүүлэх хугацаа / сараар/ |    |    |    |    |    |    |    |    | Хариуц<br>ах эзэн | Хүлээгд<br>эж буй<br>үр дүн |
|---|-------------------------|-------------------------------|----|----|----|----|----|----|----|----|-------------------|-----------------------------|
|   |                         | 9                             | 10 | 11 | 12 | 01 | 02 | 03 | 04 | 05 |                   |                             |
| 1 |                         |                               |    |    |    |    |    |    |    |    |                   |                             |
| 2 |                         |                               |    |    |    |    |    |    |    |    |                   |                             |
|   |                         |                               |    |    |    |    |    |    |    |    |                   |                             |
|   |                         |                               |    |    |    |    |    |    |    |    |                   |                             |
|   |                         |                               |    |    |    |    |    |    |    |    |                   |                             |
|   |                         |                               |    |    |    |    |    |    |    |    |                   |                             |
|   |                         |                               |    |    |    |    |    |    |    |    |                   |                             |
|   |                         |                               |    |    |    |    |    |    |    |    |                   |                             |
|   |                         |                               |    |    |    |    |    |    |    |    |                   |                             |
|   |                         |                               |    |    |    |    |    |    |    |    |                   |                             |
|   |                         |                               |    |    |    |    |    |    |    |    |                   |                             |
|   |                         |                               |    |    |    |    |    |    |    |    |                   |                             |

Монгол улсын их сургуулийн ректорын  
 2025 оны 11 сарын 17-ний өдрийн  
 А/539 тоот тушаалын 05 дугаар хавсралт



БАТЛАВ:  
 СУРГАЛТ, ОЮУТНЫ ХӨГЖИЛ ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР  
 ...../

### ТӨСӨВТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Зорилго:  
 Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:  
 Хаана:  
 Хэзээ:  
 Хамрах хүрээ:  
 Үйл ажиллагааны хөтөлбөр:

| № | Хугацаа       | Үйл ажиллагаа | Агуулга |
|---|---------------|---------------|---------|
| 1 | 10:30 – 12:00 |               |         |
| 2 | 12:00 – 12:05 |               |         |

### Үйл ажиллагааны төсөв:

|   |      |  |  |  |  |
|---|------|--|--|--|--|
| 1 |      |  |  |  |  |
| 2 |      |  |  |  |  |
|   | Нийт |  |  |  |  |

Хянасан: ОХГ-ийн мэргэжилтэн

ОХГ-ийн ахлах мэргэжилтэн  
 ОХГ-ийн дарга

Боловсруулсан: Клубийн тэргүүн .....

Утас: .....